

**МОНГОЛЧУУДЫН ШУВУУЛАХУЙ АГНУУРЫН  
ЗАРИМ УЛАМЖЛАЛААС**  
(Ойрад Монголын жишээн дээр)

**Б.Батмөнх**

Монгол Улсын Их сургууль, Ховд дахь салбарын багш, докторант

**Түлхүүр үг:** шувуу, шувуулахуй

Монголчуудын ан агнуурын нэгэн төрөл нь шувуу агнах явдал билээ. Монголчуудын хувьд шувуулахуй нь:

**Нэгдүгээрт:** Харцага, шонхор, бүргэд зэрэг хүчтэн шувуудыг тэжээж ан бариулах

**Хоёрдугаарт:** Шууд шувуу агнах гэсэн хоёр төрөл зүйл байжээ.

Монголчуудын эртний түүх шастир, дүрслэх урлагийн бүтээл, хэл шинжлэлийн дурсгал тэргүүтнийг хянан үзэхэд шувуулахуйн талаар үлэмж цэгцэрсэн мэдлэг бүхий ард түмэн байсан нь илэрхий байна.

Монголчуудын харцага, шонхор, бүргэд зэрэг хүчтэн шувуудыг буйлуулан сургаж ан хийж ирсэн түүхэн уламжлалын талаар урьд өмнө зарим нэг судлаач бичиж тэмдэглэж байсан билээ. Харин шувууг шууд аgnаж байсан уламжлалын талаар бичиж тэмдэглэсэн нь нэн ховор юм. Чингээд сайхь өгүүлэлд шувуулахуй агнуурын нэгэн төрөл болох шувууг шууд аgnаж ирсэн зарим уламжлалыг Ойрад Монголын жишээн дээр тоймлон өгүүлсүгэй.

Ойрад Монголчууд нь Монгол орны баруун бүс нутагт Алтайн их уулархаг мужийн баруун болон төв хэсэг, Хангайн уулархаг мужийн өрнөд бусийн зүүн хойд хэсэг, Их нууруудын хотгорын хуурай хээр говийн муж, Алтайн өвөр говийн хэт хуурай целийн хэсэгт тус тус аж төрөн суудаг. Тэдний нутаглан сууж буй газар оронд жигүүртний аймаг нэн баялаг. Гэвч Ойрад Монголчуудын хувьд тохиолдсон шувуу бүрийг агнаад байдаггүй, харин хойлог /Tetraogallus altaicus/, цэвдгийн ятуу /Lagopus mutus/, тоодог /Otis tarda/, ятуу /Perdix dauurica/, гургуул /Phasianus colchicus/, борцгор хотон /Pelecanus crispus/ зэрэг шувуудыг хүнсэнд болон эмчилгээ сувиллын, ахуйн зориулалтаар агнаасаар иржээ.

Алтайн уулсын нэгэн амьд эрдэнэ бол хойлог шувуу юм. Баруун бүс нутгийн олон ястнууд хойлогийг «Ulir» хэмээн нэрлэнэ. Уг шувуу тахианаас биеэр томгүй бөгөөд хөх бордуу зүстэй. Монгол орны хувьд хойлог шувуу Монгол Алтай нуруунаас гадна Говь-Алтайн нуруу, Алтайн цаадах говийн уулс, Хангайн нуруу, Хөвсгөл, Тагын нурууны салбар уулсаар тархжээ. Алтайн хойлог гагцхүү өөрийн амьдралд тохиорохуйц өндөр уулын орчинд байршин амьдрагч шувуу юм. Биологичдын ажиглалтаар, Алтайн хойлог нугын болон уулын хээрийн бүслүүрт ихэнх тохиолдолд элгэн байц цохио, ханан хад, хавцал хясаа харьцангуй цөөтэй, нураг, асга элбэгтэй, бараг ой модгүй, хавтгайдуу буюу бөмбөгөрдүү хяртай уулын энгэр хажуу, хунх, нугачаа, судаг, салбар жижиг уулсын орой орчмын цохио хадны хоорондох тэгшдүү талбай, задгай хяр зоод байршиж байдаг байна<sup>1</sup>.

Алтайн хойлог хамгийн амт чанар бүхий сөлтэй ургамлыг түүж иддэг. Хойлогны тэжээлийн ургамал хэрэглэх байдлыг өрөнхийд нь 3 ангилж үздэг байна. Үүнд:

- 1.Үетэн буурцагтан
- 2.Ургамлын ногоон хэсэг /нахия, навч, найлзуур/
- 3.Ургамлын газар доорх хэсэг /булцуу, өвөлжих нахия, үндэс, үндэслэг иш/ зэрэг болно<sup>2</sup>.

<sup>1</sup> Зориг. Алтайн хойлог. УБ., 1989. т.39

<sup>2</sup> Мөн тэнд. Тал 74

Алтайн хойлог ийнхүү сөлтэй ургамал сорчлон түүж иддэг учраас Ойрад Монголчууд эрт үеэс агнаж махыг нь эмчилгээ сувиллын зориулалтаар хэрэглэсээр иржээ. Ойрад Монголчуудын дунд «Эрт дээр үед алс хол аян дайнд явах болвол нутгийнхаа шувууны шөлийг заавал ууж, яс махыг нь нүдэж няцалж, борцолж аваад далдын далд хадгалдаг, шархадсан үедээ уух буюу нунтаглан цацаж сэмхэн хэрэглэдэг байжээ. Учир нь харь нутагт их байлдаан болж хэдэн мянган цэрэг шархдахад аравт, зуут, түмтийн ноёдууд өсөх наснаасаа хойлогны мах идэж өссөн цэрэг эрс байна уу гэж сурагладаг байсан гэлцэх бөгөөд гэнэ алдаж ам нээсэн хүнийг түмэн олны тусын тулд тэр дор нь цаазалж махыг нь хэсэгчлэн хуваагаад бүх шархдагсадад тараан өгч эмчилж эдгэрүүлдэг байсан» тухай домог яриаг өнөө хүртэл ярьцаадаг. Хойлогийн мах, шөл нь шарх эдгээх, цус төлжүүлэн тамир тэнхээ оруулах, биеийн эсэргүүцлийг сайжруулах зэрэг олон талын үйлчилгээтэй аж. Бас сүүлний өдийг нь эмэгтэйчүүдийн өвчнийг анагаахад хэрэглэдэг байна. Ойрад Монголчууд хойлогийн мах нэг удаа идсэн хүнд шарх, сорви баалж хувилахгүй дархлал тогтдог гэж үздэг.

Нутгийн ардууд намрын адаг сараас эхлэн хавар ногоо цухуйж гарах хүртэл хугацаанд буюу голдуу 9-12-р сард агнаж эмчилгээ сувиллын зорилгоор ашигладаг байна. Хойлогийг сэргүүн улиралд агнах нь зохимжтой гэж үздэг. Хойлогны өвлийн хоноглох байр totмол нэг газар, бартаа ихтэй уулсын орой, хяр орчмоос арай доохно талд хадан цохионы нөмөрт голдуу байдаг ажээ. Өвлийн орой хойлог идээшилж гүйцсэний дараа удалгүй байр хэвтрин зүг нисэж цугладаг байна. Ойрад Монголчууд хойлог агнахдаа эхлээд хоноглох газрыг нь тодорхой мэдсэний дараа сахиж байгаад урхи, хавхаар агнадаг. Бас сахиж байгаад буудаж агнана. Үнийгээ «Хойлогны хондого»-нд сууна гэж хэлэлцдэг.

Ойрад Монголчуудын эртнээс агнаж байсан бас нэгэн шувуу бол цэвдгийн ятуу юм. Энэ шувууг Ойрад Монголчууд «Ахууна», «Гахууна» гэх зэргээр нэрлэдэг. Мөнхүү шувуу Алтай нурууны зарим хэсэг хийгээд Хангайн нуруунд далай түвшнээс дээш 2200 метрээс дээш өндөрт байршин амьдардаг байна<sup>3</sup>.

Баруун Монголын олон ястнууд ахууныг намар, өвлийн цагт ихэвчлэн агнадаг. Ахууны цусыг их ид шидтэй гэж ярилцдаг. Ахууны цусны тухай нэгэн домог өнөө хүртэл яригдааар иржээ. Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн иргэн, Тува анчин О.Цэрэнпилийн өгүүлснээр: «Эрт урьд цагт нэгэн анчин өвгөн амьдран суудаг байжээ. Тэр өвгөн ганц хүйтэй гэнэ. Гэтэл тэр өвгөнд өш хонзоронтой нэгэн лам байж гэнэ. Нэгэн өдөр тэр лам өвгөнийг эзгүй араар хүүхдийг нь дагуулан анд яваад нэгэн буга алжээ. Тэр лам хүүг яаж хорлох вэ? гэж бодож байгаад бугын чөмгийг тасдаж махыг нь шулж галд шараад, хувхайрсных нь дараа чөмгөө цохиж чөмгийг нь /голыг/ идүүлжээ. Тэгээд араас нь хүү минь цангана, ус уу гээд хүйтэн ус уулгасан байна. Үүний дараа тэр хоёр харьж гэнэ. Ингээд хүүхдийн хodoод гэдсэн дотор нь юм өвдөөд байна гэж явсаар 2-3 жилийн дараа нас барж гэнэ. Гэтэл энэ үед өнөөх лам бас нас барсан байна. Нэгэн өдөр өвгөн хүүгийнхээ шарилын хажуугаар явж байгаад тарсан ясных нь дунд сөөм хиртэй цагаан шар өнгийн хатуу зүйл байсныг авч яваад гэртээ ирж түүгээр хутганы иш хийжээ. Өвгөн сайн анчин хүн байсан учир алсан ангаа тэрхүү хутгаараа төхөөрдөг байжээ. Тэгээд нэг өдөр өвгөн ахуун алж уг хутгаараа цээжийг нь ярахад хутганы иш нь хайлаад уналахад гэнэ. Үүнийг үзээд өвгөн хэсэг зуур бодож сууснаа тэр үед л муу хүүдээ ахууны цус уулгадаг байж дээ гэж амаа барьсан гэдэг. Тэгээд өвгөн нутгийн ард түмэндээ ахууны цус бол эм гэдгийг хэлж мэдүүлсэн байна. Тэр цагаас хойш нутгийн хүмүүс ахууныг эмчилгээ, сувиллын зорилгоор агнах болсон»> гэнэ.

Ахууныг ихэвчлэн буудаж агнадаг байжээ. Ахуун нь өвлийн цагт сүүлнээс бусад хэсэг нь цагаан өдеөр хучигдана. Өвлийн хүйтэн үед цасан доогуур шурган орж хоноглоно. Иймд өвлийн цагт түүнийг агнахад их төвөгтэй байдаг бөгөөд

<sup>3</sup> Фомин В.Е., Болд А. Каталог птиц Монгольской Народной Республика. М., 1991.стр.125.

туршлагатай анчид л агнадаг. Хавар гуужиж, зун, намрын улиралд хүрэн улаавтар өнгөтэй болно. Намар өвлийн улиралд сүргээрээ амьдрана. Ахууны цус болон маҳыг нь эмчилгээний зориулалтаар хэрэглэдэг байсан бөгөөд өнөөдөр ч гэсэн эл хэрэглээ уламжлагдаа байна.

Ойрад Монголчуудын агнаж ирсэн бас нэгэн шувуу бол гургуул юм. Тэд гургуулыг өд сөд нь цас бороонд норж нисэх чадвар муудсан буюу хэт идэж бие нь хүндэрч цатгалдсан үед буух газрыг нь тогтоосны дараа хөөж барьдаг байжээ. Гургуулын мах амт чанар, шингэц сайтай. Гургуул нь урт сүүлтэй, солонгорсон гоёмсог зүстэй. Гургуул нь Монгол орны баруун хэсэгт Бөхмөрөн, Ховд голын шугуй, Зэргийн хөндий, Ачит нуурын хөвөөгөөр тохиолддог<sup>4</sup>.

Ойрад Монголчууд өвлийн цагт гургуул, ятуунд урхи тавьдаг байжээ. Ер нь Монголчууд эрт цагаас шувуунд урхи тавьж байсан бөгөөд үүнийг нотлох баримт хэрэглэгдэхүүн ч бий. «Монголын нууц товчоо» зохиолын 26-р зүйлд: Онон, Хэрлэн, Туул гурван голын язгуурын Монгол аймгийн эзэн Бодончар Х зууны үед Онон голын хөвөөнд өвсөн овоохойд сууж харцага шувууг хялгасан урхиар барьж байсныг тэмдэглэсэн нь бий. Үүнийг сийрүүлвээс: <<...Teyin aqui-dur-iyan boro cino qarciyai qara quru bariju iden bukui-yi ыјеји yol daaritu γodoli seyltъ oroγ ^ingqula-yin kilyasun-bar hurayalaji bariju asaraba>><sup>5</sup> гэжээ.

Булган голын савд нутаглан сууж буй Торгуудууд ятууг хялгасан урхиар барьдаг байжээ. Ятуу ихэвчлэн сүрэглэж явдаг тул урхинд орохдоо түгээмэл. Чингэж агнахдаа ятууны хоноглох газар нарийн хэц татаж хэцнээс хялгасан урхинууд зүүж, тариа будааны зүйл цацаж орхино. /Зураг-1/ Ингэхийн хамт шувууд хоноглох газраа ирж цацсан өгөөшийг түүж идэж байгаад урхинд ордог байна. Урхинд орсон шувуу хөдлөх бүрт урхи чангач шувуу боогдох буюу эс бөгөөс орооцолдож хөдөлж чадахаа больж бээрч үхнэ<sup>6</sup>. Ойрад Монголчууд гургуулыг өгөөшөөр хуурч урхидан барьдаг байжээ. Шинжааны Ойрадууд гургуулд тавьдаг урхийг «Шавдуур урхи», ятуу барих урхийг «Жил урхи» гэж нэрлэдэг байжээ. Шавдуур урхийг хялгас хийгээд бат бөх утсаар хийж урхия модны салаагаар унжуулан газарт тээглүүр бүхий гадас шааж, тэрхүү гадаснаас хөндлөн modoор торгоод доош унжуулан гургуулын жим дээр тавина. Чингээд гургуул урхинд орох үед дүүжилж авдаг байна<sup>7</sup>. Булган голын Торгуудууд бас шувуунд тор тавьж байжээ. /Зураг-2/

Баруун Монголын олон ястнууд гургуул, тоодогийг их төлөв хүнсний зориулалтаар агнаж байжээ. Тухайлбал, Монголчуудын дунд <<тоодогийн мах тогоо дүүрнэ>> хэмээх үг хэллэг ч бий. Харин ятууны мах, шөлийг мэдрэлийн ядаргаанд маш сайн гэж хэлэлцдэг бөгөөд энэ зорилгын үүднээс үг шувууг агнасаар иржээ.

Ойрад Монголчуудын агнаж ирсэн бас нэгэн шувуу бол борцгор хотон юм. Энэ шувуу бие том, 13 кг хүртэл жинтэй, өргөн хошуутай. Монгол оронд Ховдын Хар-Ус нуурт өндөглөдөг. Загас ургамал ихтэй томоохон нуур, голын адгаар өндөглөнө. Ойрадууд хотонгийн маҳыг хүнсэнд хэрэглэдэггүй, харин хошуугаар нь хурдан морины хусуур хийдэг байна. Ойрадууд хотонгийн хошуугаар хурдан морины хусуур хийвэл өлзий дэмбэрэлтэй гэж үздэг. Ийнхүү хотонгийн хошуугаар хурдан морины хусуур хийдэг нутгийнхны заншил тоо толгойг нь үлэмж хомсдуулжээ. Эдүгээ хотонгийн тоо толгой нэн ховордоод байгаа бөгөөд 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын улаан ном, Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад тус тус оруулжээ<sup>7</sup>.

<sup>4</sup> Монгол улсын улаан ном. УБ., 1997.т.110


<sup>5</sup> Монголын нууц товчоо /галиглаж хэвлүүлсэн Т.Дашцэдэн/ УБ., 1995.т.15]

<sup>6</sup> Батмөнх Б. Ойрад Монголчуудын ан агнуурын уламжлалт зэвсэг. Ховд., 1997.т.31

<sup>7</sup> Эрэнжэй Ж., Намжил Т. Ойрад зан заншил. Юрэмчи., 1995. т. 111

<sup>7</sup> Монгол улсын улаан ном. УБ., 1997.т.86

## Хавсралт



Зураг-1. Шувууны урхи



Зураг-2. Шувууны тор

Ойрад Монголчууд хотон шувуу агнахын өмнө зарим нэг шившлэг үйлддэг байжээ. Учир нь тэдний дунд хотон шувуу буудуулж унахдаа хошуугаа заавал хугалж унадаг. Энэ нь морины хусуур хийлгэхгүйн тулд хошуугаа хугалдаг гэсэн ойлголт өргөн тархсан байдаг. Иймд хотонгийн хошууг хугалахгүй авахын тулд хамгийн хайртай малаа амалж бууддаг зан үйл байжээ. Энэ нь үгийн хүч, идшидээр дамжуулан түүнд нөлөөж, хүсэл зоригоо ойлгуулж зорилгодоо хүрч болно хэмээн үздэг эртний шүтлэгийн нэгэн төрөл болох дом шившлэгийн /смаги/ ёсны улбаа юм.

Эцэст нь тэмдэглэхэд Ойрад Монголчууд зарим ан агнуурын шувуудыг эмчилгээ сувиллын болон хүнсний, ахуйн зориулалтаар агнаж ирэхдээ тэдгээр шувуудын байршин амьдрах газар орныг нарийн тогтоосны дараа ааш аяг, идэш хоолоо эрж гүйх гүйдэл, нүүдэл тэргүүтэнд нийцсэн өвөрмөц багаж хэрэгсэл, арга тэргүүтнийг сонгож агнасаар ирсэн байна.

**Resume**

**B.Batmunkh**

***Some tradition of <<sibalaqui>> hunting methods  
of Oirat Mongols***

***This article is about some traditional methodizes how to hunt birds which is one kind <<sibalaqui>> of Oirat Mongols. Oirat Mongols used certain methodizes and appliances that is suited to the birds characteristics, seeking the food and migration.***